



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.21 № 1/64

МИАТ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА

Гэрээний дагуу төлөх төлбөрийг
нөхөн төлүүлэх тухай

Цагдаагийн ерөнхий газрын Улсын мөрдөн байцаах газрын даргын хүсэлт, түүний баталсан удирдамжийн дагуу Үндэсний аудитын газар, Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос томилогдсон ажлын хэсэг МИАТ ХК-ийн санхүүгийн зарим үйл ажиллагаанд шалгалт хийлээ.

Шалгалтаар МИАТ ХК билет борлуулагч агентуудтай суудал захиалгын системийн терминал (PID) ашиглуулах эрх олгох, билет хэвлэх автомат төхөөрөмж түрээсээр ашиглуулах гэрээ хийсэн боловч санхүүгийн албанд эдгээр гэрээний талаарх мэдээлэл байхгүй, гэрээний хувийг өгөөгүй гэдэг шалтгаанаар гэрээнд заасан суудал захиалгын систем ашиглах терминалын лицензийн төлбөр нийт 35,835,181.79 төгрөгийг хавсралтад дурдсан билет борлуулагч агентуудаас нэхэмжилж аваагүй байгууллагыг хохироосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ", 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах", мөн МИАТ ХК-ийн хавсралтад заасан компанитай байгуулсан суудал захиалгын системийн терминал ашиглах, автомат билет хэвлэх тоног төхөөрөмжийг түрээслүүлэх гэрээний 6.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад заасан компаниудаар суудал захиалгын систем ашиглах терминалын лицензийн төлбөр нийт 35,835,181.79 төгрөгийг нөхөн төлүүлж, МИАТ ХК-ийн Голомт банкин дахь 1102036061 тоот дансанд төвлөрүүлэх,

07J202

2. Тогтоосон төлбөрийг 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор барагдуулж, төлбөрийн актын биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Жаргалсайхан, Санхүү, эдийн засгийн газрын дарга Ч.Даваасүрэн нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газрын менежер Ж.Батсайхан, Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Болормаа нарт даалгав.

АКТ

ТОГТООСОН:

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

Стратегийн удирдлагын газрын менежер



Ж.Батсайхан

Нийцлийн аудитын газрын ахлах аудитор

Б.Болормаа

МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал



Г.Жаргалсайхан

Санхүү, эдийн засгийн газрын дарга

Ч.Даваасүрэн